

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх онцгой чиг үүрэг бүхий шүүгчид тавих шаардлага, шүүгчийн бүрэн эрх үүсэх ба дуусгавар болох үндэслэл, журам, шүүгчийн хараат бус байдал, түүнийг хангах баталгаа, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэрэг шүүгчийн эрх зүйн байдалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

2.1.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Шүүгчийн хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбогдсон энэ хуульд заагаагүй бусад харилцааг Хөдөлмөрийн тухай, Шүүхийн тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“шүүгч” гэж хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдон, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг сахиулан хамгаалахаар тангараг өргөн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэнийг;

3.1.2.“шүүгчид нэр дэвшигч” гэж хуульд заасан шүүгчээр ажиллах болзол, шаардлагыг хангасан, шүүгчийн сул орон тоонд нэрээ дэвшүүлсэн иргэнийг, эсхүл дээд шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэрээ дэвшүүлсэн шүүгчийг;

3.1.3.“нөлөөллийн мэдүүлэг” гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хэргийн шийдвэрлэлттэй холбогдуулан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс аливаа хэлбэрээр нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан, эрүү, иргэн, захиргааны хэргийн материалд хавсаргагдах баримт бичгийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

4 дүгээр зүйл.Шүүгчид тавих шаардлага

4.1.Шүүгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол болон дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1.ял шийтгүүлж байгаагүй байх;

4.1.2.нэр дэвших үед гэмт хэрэгт холбогдоогүй буюу сэжигтэн, яллагдагчаар татагдаагүй, бусдад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;

4.1.3.шүүгчээр ажиллахад саад болох буюу сөргөөр нөлөөлөхүйц эрүүл мэндийн болон сэтгэцийн өвчин эмгэггүй байх;

4.1.4.хуульчийн мэргэжлийн тусгай зөвшөөрөл авсан байх;

4.1.5.мэдлэгээ байнга дээшлүүлж байх хичээл зүтгэлтэй, ажилдаа амжилт гаргасан байх;

4.1.6.мэргэжлийн ёс зүйгээ өндрөөр ухамсарласан, шударга ёсыг эрхэмлэдэг, бусдын нөлөөнд авталгүй бие даасан шийдвэр гаргах чадвартай байх;

4.1.7.бусдын эрхийг хүндэтгэдэг, хүлээцтэй, сонсох чадвартай байх;

4.1.8.монгол хэлний ярианы болон бичгийн өндөр соёл, чадвартай байх;

4.1.9.мэдээллийн технологийн хэрэглээний программыг ашиглах чадвартай байх.

4.1.9. Шүүгчээр ажиллах тухайн дагнасан шүүхийн салбар эрх зүйн мэдлэг, туршлагатай байх

4.2.Эрхэлж байгаа албан үүрэгтэй нь холбогдуулан шүүгчид тавих тусгайлсан шаардлагыг зөвхөн энэ хуулиар тогтооно.

5 дугаар зүйл.Давж заалдах шатны шүүхийн шүүгчид тавих тусгай шаардлага

5.1.Давж заалдах шатны шүүхийн шүүгч энэ хуулийн 4.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

5.1.1.анхан шатны шүүхэд шүүгчээр 3-аас доошгүй жил ажилласан, эсхүл өмгөөлөгч, прокуророор нийтдээ 5-аас доошгүй жил ажилласан, шүүн таслах ажиллагааны туршлагатай байх;

5.1.2.бусдын санал бодолд хүндэтгэлтэй хандаж, шүүмжлэлийг бодитойгоор хүлээн авч, өөрийн байр суурийг ойлгомжтой тайлбарлах зэрэг асуудлыг олонхийн зарчмаар шийдвэрлэхэд шаардлагатай зан чанартай байх;

5.1.3.шийдвэрлэсэн хэргийн хүрээнд судалгаа, дүгнэлт хийх чадвартай байх;

5.1.4.мэргэшсэн чиглэлээр хэрэглэгддэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болон хуулийн зүйл, заалтыг зөв хэрэглэх талаар мэргэжлийн хэвлэлд өгүүлэл бичин, нийтлүүлсэн байх.

6 дугаар зүйл.Хяналтын шатны шүүхийн шүүгчид тавих тусгай шаардлага

6.1.Хяналтын шатны шүүх шүүгч буюу Улсын дээд шүүхийн шүүгч энэ хуулийн 4, 5 дугаар зүйлд заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

6.1.1.мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан;

6.1.2.шүүгчээр ажиллах хугацаандаа шүүгчийн хараат бус байх зарчмыг сахин, шүүгчийн хувьд ноцтой алдаа гаргаж сахилгын болон бусад хариуцлага хүлээж байгаагүй, эрх зүйн мэдлэг, соёл, хувийн үлгэр жишээч байдлаараа олон нийтэд нэр хүндтэй, хуульчдын дунд хүлээн зөвшөөрөгдсөн байх.

7 дугаар зүйл.Ерөнхий шүүгчид тавих шаардлага

7.1.Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч энэ хуулийн 4-6 дугаар зүйлд заасан шүүгчид тавих шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

7.1.1.анхан болон давж заалдах шатны шүүхэд 3-аас доошгүй жил ажилласан; Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн хувьд 10-аас доошгүй жил ажилласан

7.1.2.удирдан зохион байгуулах авьяас чадвартай байх;

8 дугаар зүйл.Мэргэжлээр ажилласан хугацаа

8.1.Мэргэжлээрээ ажилласан хугацаанд дараах хугацааг тооцно:

8.1.1.Хуульчийн мэргэжлийн тусгай зөвшөөрөл авсны дараа өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажилласан, түүнчлэн хуулийн байгууллагад удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажилласан, төрийн болон бусад байгууллагад хуулийн зөвлөх буюу хуулийн мэргэжилтнээр ажилласан хугацааг;

8.1.2.Үндсэн хуулийн цэц болон олон улсын шүүх, арбитраж хуульчийн мэргэжлээр ажилласан хугацааг;

8.1.3.их, дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагад багш, эрдэм шинжилгээний ажилтны орон тоонд ажиллан эрх зүйн асуудлаар үндсэн хичээл

зааж, судалгаа хийж сурах бичгийн түвшинд бүтээл туурвисан багш, эрдэм шинжилгээний орон тооны ажилтны, түүнчлэн хууль зүйн доктор, дэд профессор, түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой хуульчийн ажилласан хугацааг.

9 дүгээр зүйл.Шүүгчид тавих шаардлагыг үнэлэх

9.1.Энэ хуулийн 4-7 дугаар зүйлд заасан шүүгчид тавих шаардлагыг үнэлж дүгнэх, шалгаруулах журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгч цаашид “Ерөнхийлөгч” гэхл батална.

9.2.Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хуулийн 9.1-д заасан журмыг тогтмол боловсронгуй болгох, шинэчлэх үүрэг хүлээнэ.

9.3.Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг 3-5 жилд дүгнэж байх шалгуур үзүүлэлт, журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл боловсруулж, Ерөнхийлөгч батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ШҮҮГЧИЙН БҮРЭН ЭРХ ҮҮСЭХ, ДУУСГАВАР БОЛОХ

10 дугаар зүйл.Шүүгчийн бүрэн эрх

10.1.Шүүгчийн бүрэн эрх нь Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасан журмын дагуу томилогдон, тангараг өргөснөөр эхэлнэ.

10.2.Шүүгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.2.1.шүүх хуралдааныг даргалах, шүүх бүрэлдэхүүнд орох;

10.2.2.шүүх хуралдааныг товлон зарлаж, түүний оролцогчдыг тогтоох;

10.2.3.шүүх хуралдааны бэлтгэлийг хангах ажлыг шүүхийн тамгын газартай хамтран зохион байгуулах;

10.2.4.хэрэг, маргааныг шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэхэд оролцох;

10.2.6.хуульд зааснаар дангаараа шийдвэрлэх хэрэг, маргааныг хянан үзэж Монгол Улсын нэрийн өмнөөс шийдвэрлэх;

10.2.7.өөрийн оролцсон шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэж байгаа асуудлаар саналаа бие даан гаргах, тусгай санал гаргах;

10.2.8.цагдан хорих асуудал хариуцсан шүүгчийн хувьд цагдан хорих хүсэлтийг хянан үзэж шийдвэрлэх;

10.2.9.шүүн таслах ажиллагааг хуульд заасан дэг журам, хугацааны дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай бол хэргийн оролцогч, өмгөөлөгч болон холбогдох этгээдийг хууль сахиулах арга хэмжээ авах шийтгэвэр гаргах;

10.2.10. тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид, түүнчлэн давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгчид нэрээ дэвшүүлэх, хуульд зааснаар Ерөнхий шүүгчийг орлох;

10.2.11. шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистик мэдээлэлд хяналт тавьж, холбогдох байгууллагад шаардлага тавих;

10.2.12. албан үүргээ цалгардуулахгүйгээр багшлах болон эрдэм шинжилгээний ажил эрхлэх, уран бүтээл туурвих;

10.2.13. хуульд заасан бусад бүрэн эрх.

10.3. Шүүгч холбогдох хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд шаардлагатай баримт бичиг, бусад мэдээлэл, тэдгээрийн хуулбарыг зохих байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардан гаргуулах эрхтэй бөгөөд тухайн этгээд нь шүүгчээс шаардсан баримт бичиг, мэдээллийг үнэ төлбөргүй гаргаж өгөх үүрэгтэй.

10.4. Шүүгч энэ хуулийн 10.3-т заасан баримт бичгийг үрэгдүүлэхгүй байх үүрэг хүлээх бөгөөд шаардлагатай бол түүнийг хуулбарлуулан авах, эх хувиар нь авсан баримт бичгийг буцааж өгнө.

10.5. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж гаргасан шүүгчийн аливаа шийдвэр тогтоол, захирамж нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад заавал биелүүлэх хүчинтэй байна.

10.6. Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх нь Шүүхийн тухай хуулиар, харин шүүгчийн хувьд хамгаалагдах эрх зүйн байдал нь энэ хуулиар тодорхойлогдоно.

11 дүгээр зүйл. Шүүгчийг сонгон шалгаруулах журам

11.1. Шүүгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх ажлыг Ерөнхий зөвлөл зохион байгуулна.

11.2. Шүүгчийг өөрийнх саналаар тухайн шатны өөр шүүхэд сэлгэн томилж болох бөгөөд энэ тохиолдолд энэ хуулийн 11.1 дэх заалт хамаарахгүй.

11.3. Ерөнхий шүүгч дараах тохиолдолд тухайн шүүхийн шүүгчийн сул орон тооны талаар Шүүхийн ерөнхий зөвлөлд мэдэгдэнэ:

11.3.1. шүүгч хүсэлтээрээ чөлөөлөгдөх, өндөр насны тэтгэвэрт гарах бол уг орон тоог сулрахаас 1 сарын өмнө;

11.3.2. энэ хуулийн 11.3.1-д зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн сул орон тоо гарсан бол уг орон тоо суларсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор.

11.4. Ерөнхий зөвлөл энэ хуулийн 11.3-т заасан мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шүүгчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх болзол, журам, нэрээ дэвшүүлэхийг хүсэгч этгээдийн өргөдлийг хүлээн авах, бүртгэх, бүртгэгдэгчдийг шалгаруулах хугацаа, журам, газрыг тодорхойлсон зарлалыг албан ёсоор нийтлэх эрх бүхий хэвлэлд болон

тухайн шүүгчийн ажиллах аймаг, нийслэлийн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, цахим хуудсандаа байрлуулна.

12 дугаар зүйл.Нэр дэвшигчийг бүртгэх

12.1.Энэ хуулийн 4,5,6 дугаар зүйлд заасан болзол, шаардлагыг хангасан гэж үзсэн иргэн шүүгчид өрсөлдөхөөр нэрээ дэвшүүлэх эрхтэй.

12.2.Шүүгчид өрсөлдөхөөр нэр дэвшигч (цаашид “нэр дэвшигч” гэх) нь өргөдөл, дараах материалыг бүрдүүлэн Ерөнхий зөвлөлд бүртгүүлнэ:

12.2.1.Монгол Улсын иргэний үнэмлэхийн хуулбар ;

12.2.2.мэргэжлийн диплом болон хавсралтын хуулбар;

12.2.3.өөрийн намтар бүхий анкет;

12.2.4.нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, хөдөлмөр эрхэлж байгааг нотлох бусад баримт бичиг, тэдгээрийн хуулбар;

12.2.5.шүүгчийн албан тушаалд томилогдоход харшлах өвчин эмгэггүйг нотолсон эмнэлгийн магадалгаа, эмчийн дүгнэлт;

12.2.6. ял шийтгэгдэж байгаагүйг нотолсон цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

12.2.7.байнга оршин суугаа газрын хаяг, ам бүлийн болон эд хөрөнгийн байдал, бусдад өр зээлгүй тухайгаа бичгээр мэдүүлэх;

12.2.8.ажиллаж байгаа бол эрхэлсэн ажлын байдал, хамт олны доторх нэр хүнд, зан төлөвийн тухай аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны тодорхойлолт.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасан материалыг шуудангаар ирүүлэх тохиолдолд тэдгээрийг нотариатаар гэрчлүүлсэн байна.

12.4. Ерөнхий зөвлөл нь нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авч, бүрдэл, үнэн зөв эсэхийг нягтлана.

12.5. Нэр дэвшигчийг бүртгэмэгц тухайн шүүхийн болон Ерөнхий зөвлөлийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

12.6. Нэр дэвшигчийн талаар олон нийтээс ирүүлсэн мэдээллийг нягтлан шалгаж, бодитой санал дүгнэлт гаргаж, Ерөнхий зөвлөлийн гишүүдэд танилцуулна.

13 дугаар зүйл.Шүүхийн Мэргэшлийн хорооны дүгнэлт

13.1. Нэр дэвшигч нь энэ хуулийн 4,5,6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг Шүүхийн мэргэшлийн хороо нь бүртгэл дууссанаас хойш 14 хоногийн дотор гарган Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.

14 дүгээр зүйл.Нэр дэвшигчийг сонгон шалгаруулах

14.1.Ерөнхий зөвлөл нь 12.2.1-12.2.8-д заасан материал, 12.6-т заасан мэдээллийг судлан үзэж, нэр дэвшигч бүртэй ганцаарчилсан ярилцлага зохион байгуулж дүгнэлт гаргана.

14.2. Ерөнхий зөвлөл нь 14.1-т заасан дүгнэлт болон Шүүхийн мэргэшлийн хорооны дүгнэлтийг үндэслэн шүүгчийн албан тушаалд томилуулах нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг гарган, санал хураан олонхийн санал авсан 2-3 хүний нэрийг ажлын 5 хоногийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

15 дугаар зүйл.Ерөнхий шүүгчийн албан тушаалд шүүгчийг сонгон шалгаруулах

15.1.Анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчид тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэр дэвшүүлнэ.

15.2.Энэ хуульд заасан шаардлагыг хангасан гэж үзсэн шүүгч тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид нэрээ дэвшүүлэх эрхтэй.

15.3.Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд шүүгчийг сонгон шалгаруулахад энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан нийтлэг журам нэгэн адил хамаарна.

16 дугаар зүйл.Шүүгчийг томилох

16.1.Анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор, Улсын дээд шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл санал болгож Улсын Их Хуралд танилцуулснаар тус тус Ерөнхийлөгч томилно.

16.2.Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосон шүүгчид нэр дэвшигчийг судлан үзэж, түүнийг томилох буюу томилохоос татгалзах шийдвэр гаргана.

16.3.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар нэг удаа томилно.

16.4.Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг 3 жилийн хугацаар томилох бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

16.5.Ерөнхийлөгч шүүгчийг томилсон тухай зарлиг гаргана.

17 дугаар зүйл.Шүүгчийн тангараг, түүнийг өргөх журам

17.1.Шүүгч томилогдсон өдрөөсөө хойш 30 хоногийн дотор хамт олон болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийн өмнө “Шүүгч би шүүх эрх мэдлийн ариун журамт үүрэг, Монгол Улсын Үндсэн хуульт байгуулал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж маргааныг хэнээс ч хараат бус, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шударга ёс, шүүгчийн ёс зүйг чанд сахиж явахаа ард түмэндээ амлан тангараглая. Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал шүүгчийн албан тушаалаас нэн даруй огцорч хуульд заасан хариуцлага хүлээнэ.” гэж Төрийн сүлдэнд тангараг өргөнө.

17.2.Шүүгчийн тангараг өргөх журам, шүүгчийн өмсгөлийн загвар, хэрэглэх журмыг Ерөнхийлөгч батална.

18 дүгээр зүйл.Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх

18.1.Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн дор дурдсан үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлнэ:

18.1.1.хуульчийн мэргэжлийн тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн;

18.1.2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилогдсон;

18.1.3.6 сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон;

18.1.4. 6 сараас дээш хугацаагаар суралцах, эрдэм шинжилгээний бүтээл туурвих болсон;

18.1.5.эрүүгийн хариуцлагад татагдсан;

18.1.6.шүүгчийг сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

18.1.7.цэргийн жинхэнэ албанд сайн дураараа татагдсан.

18.2.Шүүгчийн бүрэн эрхийг энэ хуулийн 18.1.1-18.1.3-т зааснаас бусад үндэслэлээр түдгэлзүүлсэн нь түүний халдашгүй байдал, цалин, эдийн засаг, нийгмийн хангамжийг хасах үндэслэл болохгүй.

18.3.Хуульчийн тусгай зөвшөөрлыг тодорхой хугацаагаар түдгэлзүүлсэн бөгөөд түдгэлзүүлсэн хугацаа дууссан, энэ хуулийн 18.1-т заасан үндэслэл арилсан бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Ерөнхийлөгч шүүгчийн бүрэн эрхийг сэргээнэ.

19 дүгээр зүйл.Шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох

19.1.Шүүгчийг Үндсэн хууль болон энэ хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас нь чөлөөлж, огцруулна.

19.2.Шүүгчээр ажиллаж болох насны дээд хязгаар 65 байна.

19.3.Шүүгч энэ хуулийн 19.2-т заасан насны дээд хязгаарт хүрээгүй боловч Хөдөлмөрийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах_насанд хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөж болно.

19.4.Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн дараах үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож чөлөөлнө:

19.4.1.шүүгч албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан;

19.4.2.эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болсон;

19.4.3.өөр ажилд шилжсэн буюу томилогдсон, эсхүл сонгогдсон;

19.4.4.Монгол Улсын харьяатаас гарах болсон, эсхүл гадаад улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух эрх авсан;

19.4.5.шүүгч улс төрийн сонгуульд нэр дэвших болсон;

19.4.6.шүүгчийн эрх зүйн чадамжийг хязгаарласан, эсхүл чадамжгүйг тогтоосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

19.4.7.шүүхийг татан буулгах, эсхүл өөрчлөн зохион байгуулахтай холбогдуулан өөр шүүхэд шилжүүлэхээс шүүгч өөрөө татгалзсан;

19.4.8.шүүгч нас барсан, эсхүл нас барсанд тооцох тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон.

19.5.Дараах үндэслэлээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн шүүгчийг огцруулна:

19.5.1.шүүгчийн албан тушаалтай хавсарч үл болох үйл ажиллагаа эрхэлсэн;

19.5.2.гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

19.5.3.хуульчийн мэргэжлийн тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон;

19.5.4.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон.

19.6.Албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж шүүгчийн хараат бус байдалд нөлөөлсөн, аль нэг улс төрийн намын талд шүүхийг үйлчлүүлсэн буюу үйлчлүүлэхээр дарамт үзүүлсэн нь Ерөнхий шүүгчийг хугацаанаас нь өмнө албан тушаалаас нь огцруулах үндэслэл болно.

19.7.Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хуулийн 19.4-19.5-д заасан үндэслэлээр шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлүүлэх, эсхүл огцруулах тухай саналыг тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш 30 хоногийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх бөгөөд Улсын дээд шүүхийн шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлүүлэх, огцруулах саналыг Улсын Их Хуралд урьдчилан танилцуулна.

19.8.Ерөнхийлөгч шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлүүлэх болон огцруулах тухай Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор уг асуудлыг шийдвэрлэнэ.

19.9.Шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгосон үндэслэл нь хууль бус байсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол шүүгчийн бүрэн эрхийг сэргээж цалин хөлсийг нь нөхөн олгоно.

20 дугаар зүйл.Шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох хугацааг тоолох

20.1.Шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох хугацааг дараах байдлаар тоолно:

20.1.1.Ерөнхий шүүгч, танхимын тэргүүний хувьд бүрэн эрх нь дуусгавар болох сарын сүүлийн өдрөөр;

20.1.2.шүүгчээр ажиллаж болох насны дээд хязгаарт хүрсэн бол уг насанд хүрэх сарын сүүлийн өдрөөр;

20.1.3.энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох шийдвэр гарсан бол уг шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөр.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ХАНГАХ БАТАЛГАА

21 дүгээр зүйл.Шүүгчийн хараат бус байх зарчим, баталгаа

21.1.Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байж, гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд захирагдана

21.2.Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар баталгаажуулна.

21.3.Энэ хууль болон бусад хуулиар тогтоосон шүүгчийн эрх зүйн хамгаалалт, эдийн засаг, нийгмийн хамгаалалт зэрэг хараат бус, халдашгүй байдлын баталгааг ямар нэг хэлбэрээр дордуулсан хууль гаргахыг хориглоно.

21.4.Шүүгчийн хараат бус байдлыг дараах баталгаагаар хангана:

21.4.1.Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд тусгайлан зааснаас өөр үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хязгаарлахыг хориглох ;

21.4.2.шүүгчийн бүрэн эрхийг Үндсэн хууль болон энэ хуульд зааснаас өөр үндэслэл, журмаар түдгэлзүүлэх ба дуусгавар болгохыг хориглох;

21.4.3.шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр албан тушаалд болон өөр шүүхэд шилжүүлэхийг хориглох;

21.4.4.шүүгч хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хугацаагүй томилогдож, хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны болон гурав дахь этгээдийн санаачилгаар чөлөөлөгдөхгүй,огцрохгүй байх;

21.4.5.шүүгчийг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд аливаа дайчилгаа болон цэргийн жинхэнэ албанд татахгүй байх;

21.4.6.шүүгчийн эрх зүйн онцгой байдалд нь нийцүүлэн эдийн засгийн болон нийгмийн хангамж, халамжийн тогтолцоог энэ хууль болон бусад хуулиар бүрдүүлж, хангах;

21.4.7.шүүгч нь хараат бус ажиллах нөхцөл нь алдагдсан буюу боломжгүй болсон хэмээн үзсэн тохиолдолд өөрөө хүсэлтээрээ чөлөөлөгдөх эрхтэй.

21.4.8. Улсын дээд шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч нь гадаадад байх, зорчих хугацаанд дипломат эрх ямба, дархан эрх эдэлнэ.

21.5.Шүүгчийн хараат бус байдалд хуульд зааснаас өөр үндэслэл, журмаар халдсан, үл хүндэтгэсэн хэн боловч хууль зүйн хариуцлага хүлээнэ.

22 дугаар зүйл.Шүүгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглох

22.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус бусад аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

22.2.Энэ хуулийн 22.1 дэх хэсгийг зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

22.3.Шүүгчээс хянан шийдвэрлэж байгаа болон хянан шийдвэрлэсэн хэргийнх нь талаар өөрийг нь холбогдуулан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтан тайлбар, мэдүүлэг авахаар шаардахыг хориглоно.

22.4.Шүүгч нь хэргийн оролцогчоос бусад этгээдэд хэргийн материалыг танилцуулах үүрэг хүлээхгүй.

23 дугаар зүйл.Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх

23.1.Тухайн хэрэг, маргааныг хянахаар хүлээн авсан шүүгч, шүүх бүрэлдэхүүн нөлөөллийн мэдүүлгийг хөтөлнө.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан нөлөөллийн мэдүүлгийн загварыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

23.3.Шүүгч нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар хэрэг үүсгэсэн даруйд тухайн хэргийн оролцогчид тайлбарлан, энэ тухай баримтжуулна.

23.4.Шүүгч нөлөөллийн мэдүүлгийг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсний дараа Шүүхийн ерөнхий зөвлөлд илгээж, хувийг нь тухайн хянан шийдвэрлэсэн хэрэг, маргааны хавтаст хэрэгт хавсаргана.

23.5.Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хуулийн 23.3-т заасан нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан тухайн этгээдийн үйлдэл нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан гэж үзвэл түүнийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж, шийдвэрлүүлнэ.

23.6.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 21.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн санал хүсэлтийн дагуу холбогдох арга хэмжээ авч, Шүүхийн ерөнхий зөвлөлд хариу мэдэгдэнэ.

24 дүгээр зүйл.Шүүгчийн эдийн засгийн баталгаа

24.1.Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна.

24.2.Тухайн шүүгчийн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан 5 дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос 1 хувиар нэмэгдэж байна.

24.3.Шүүгч нь ажлын ачаалал, бүтээмж, шийдвэрийн чанар зэрэгтэй уялдсан нэмэгдэл авна. Энэхүү нэмэгдэл нь энэ хуулийн 9.3 дугаар зүйлд заасан мэргэшлийн үнэлгээний үр дүнгээс хамаарах ба нэмэгдлийн хэмжээ үндсэн цалингийн 50 хувь хүртэл байна. Нэмэгдэл олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл УИХ-ын төсөв болон хууль зүйн асуудал эрхэлсэн байнгын хороодтой хамтран боловсруулж, Ерөнхийлөгчөөр батлуулна.

24.4.Улсын Их Хурал Шүүхийн тухай хуулийн 28.3-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс өргөн мэдүүлсэн шүүхийн төсвийн шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулахгүйгээр батална.

24.5. Хуульд заасан нас, болзолын дагуу тэтгэвэрт гарсан шүүгчид сүүлийн нэг жилийн цалингийн дундажаар тооцон 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг

удаагийн тэтгэмжийг олгоно. Тэтгэвэртэй холбоотой харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

24.6.Шүүгчийн ээлжийн амралтын үндсэн хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоох бөгөөд шүүгчээр ажилласан 5 жил тутамд ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

24.7.Шүүгчийн албан ёсны айлчлал, томилолт, төрийн ёслол, хүндэтгэлийн болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээний зардлыг шүүхийн төсвөөс санхүүжүүлнэ.

24.7.Шүүгч ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл төрсөн нутагтаа амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардлыг шүүхийн төсвөөс авто замын зорчигч тээврийн зардлаар тооцож олгоно.

25 дугаар зүйл.Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний нийгмийн хамгаалалт

25.1.Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг улсын төсвөөс хариуцна.

25.2.Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал дараах хэлбэр, хэмжээтэй байна:

25.2.1.шүүгч ажил үүргээ гүйцэтгэж байхдаа бие махбод нь бэртсэн буюу эрүүл мэндэд нь гэмтэл учирснаас нас барсан бол даатгалын төлбөрийг түүний авч байсан сүүлийн 15 жилийн цалинтай тэнцэх хэмжээгээр шүүгчийн өв залгамжлагчид төлөх;

25.2.2. шүүгч ажил үүргээ гүйцэтгэж байхдаа бие махбод нь бэртсэн буюу эрүүл мэндэд нь цаашид мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж чадахааргүй гэмтэл учирсан бол даатгалын төлбөрийн хэмжээ нь тухайн шүүгчийн сүүлийн 3 жилийн цалинтай тэнцэх;

25.2.3.шүүгчийн бие махбод, эрүүл мэндэд хохирол учруулсан нь түүний хөдөлмөрийн чадварыг цаашид мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэхэд саад болохоор алдагдуулаагүй бол тухайн шүүгчийн сүүлийн 1 жилийн цалинтай тэнцэх хэмжээгээр тус тус даатгалын төлбөрийг улсын төсвөөс гаргаж даатгалын байгууллагаас төлнө.

25.3.Шүүгч ажил үүргээ гүйцэтгэж байхдаа холбоотойгоор шүүгч бэртсэн болон эрүүл мэндэд нь өөр гэмтэл учирснаас цаашид мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүйгээр хөдөлмөрийн чадвараа алдсан бол түүнд шүүгчээр ажиллаж байхдаа авч байсан цалингийн 70 хувьтай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг сар бүр олгоно.

25.4.Шүүгч ажил үүргээ гүйцэтгэж байхдаа шүүгч нас барвал түүний асрамжид байсан хүүхдийг 18 нас хүртэл нь, гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй

гишүүнд шүүгчийн авч байсан албан тушаалын цалингаас ногдох хэмжээгээр тэтгэмж /нөхөх төлбөр/-ийг сар бүр олгох бөгөөд түүнд улсын төсвөөс төлсөн даатгалын төлбөр, тэжээгчээ алдсаны болон бусад төрлийн тэтгэвэр, цалин, тэтгэлгийг оруулан тооцохгүй.

26 дугаар зүйл.Шүүгчийн мэргэшлийн түвшинг дэмжих

26.1.Шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, мэргэшлээ дээшлүүлж байх үүрэгтэй бөгөөд жил бүр сургалтад хамрагдаж байна.

26.2.Шүүгч мэргэшил дээшлүүлэх сургалтын хугацаанд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгоно.

26.3.Шүүгчийн мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл зохион байгуулна.

27 дугаар зүйл.Шүүгчийн халдашгүй байдал

27.1.Шүүгч халдашгүй эрхтэй бөгөөд түүнийг энэ хууль болон бусад хуулиар тогтоон хамгаална.

27.2.Шүүгчийн халдашгүй байдалд дараах зүйл хамаарна:

27.2.1.амь бие;

27.2.2. ажлын байр, хувийн болон албаны орон сууц;

27.2.3.эзэмшиж, ашиглаж байгаа хувийн болон албаны тээвэр, холбооны хэрэгсэл;

27.2.4.өөрийнх мэдэлд нь байгаа бичиг баримт, ачаа тээш, бусад эд хөрөнгө;

27.2.5.захидал харилцааны нууц, тухайлбал, шүүгчийн харилцах бүх төрлийн утасны яриа, шуудан цахилгаан, өөр аливаа хэлбэрээр бусдад илгээж байгаа болон хүлээн авч байгаа мэдээллийн нууц.

27.3.Шүүгч хэрэв эрх мэдлээ урвуулан ашигласан, илт хууль бус таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, шүүхийн бусад акт гаргасан гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор нотлогдоогүй бол бүрэн эрх нь дуусгавар болсны дараа шүүн таслах ажил эрхэлж байх үедээ илэрхийлсэн санаа бодол, гаргасан шийдвэрийнх нь төлөө түүнийг ямар нэгэн хариуцлагад татахыг хориглоно.

27.4.Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, аюулгүй байдалд аюул занал учрах нөхцөл үүссэн болон энэ тухай мэдээлэл авсан бол цагдаагийн байгууллага энэ байдлыг таслах зогсооход чиглэсэн арга хэмжээг нэн даруй авах үүрэгтэй.

27.5.Энэ хуулийн 27.4-т заасан арга хэмжээг авах нөхцөл, журмыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, цагдаагийн төв байгууллагын дарга хамтран батална.

27.6.Шүүгч нь аюулгүй байдлаа хамгаалах зорилгоор бие хамгаалах хэрэгслийг эзэмших, биедээ авч явах эрхтэй.

ТАВДУГААР БҮЛЭГ ШҮҮГЧИЙН ХАРИУЦЛАГА

28 дугаар зүйл. Шүүгчид хориглох зүйл

28.1.Шүүгчид дараах зүйлийг хориглоно:

28.1.1.энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхээ урвуулан ашиглах;

28.1.2.шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гараагүй байхад өөрийн байр суурийг олон нийтэд мэдээлэх, илэрхийлэх;

28.1.3.албан үүрэгтэй нь холбогдож илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулах;

28.1.4.албан ажлын хэрэгцээнд зориулсан материал, техник, санхүү, мэдээллийн хэрэгслийг шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зориулалтаар эдэлж ашиглах;

28.1.5.олон нийтэд мэдээлэхийг хязгаарласан, эсхүл албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, задруулах, шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зорилгоор ашиглах;

28.1.6.шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон бусад иргэн, хуулийн этгээдээс шууд ба шууд бусаар тусламж авах, үйлчлүүлэх, ямар нэгэн давуу байдал, хөнгөлөлт, мөнгөн болон бусад урамшуулал, хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй шагнал авах;

28.1.7.өөрийн болон гэр бүлийнх нь, түүнчлэн албан байгууллагынх нь эрх ашиг хөндөгдсөнөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдийн хууль ёсны төлөөлөгч байх;

28.1.8.шүүгч нь Ерөнхий шүүгч, шүүгчтэй гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн холбоотой бол тухайн шүүхэд ажиллах;

28.1.9.өөрөө, эсхүл итгэмжлэгдсэн этгээдээр дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, аж ахуйн нэгж, тэдгээрийн холбоо, нэгдлийн удирдах бүрэлдэхүүнд зохион байгуулалт, эрх зүйн аливаа хэлбэрээр түр болон байнга оролцох;

28.1.10.Монгол Улсын олон улсын гэрээ, гадаад улсын шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад гадаад улс болон олон улсын байгууллага, гадаадын харьяат иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр багшлах, эрдэм шинжилгээний болон бусад ажил эрхлэх;

28.1.11.шинжлэх ухаан, спортоос бусад гадаад улсын засаг төр, олон нийтийн болон бусад байгууллагын хүндэт, тусгай цол, шагнал, одон, тэмдэг авах;

28.1.12.Монгол Улсын олон улсын гэрээгээр болон гадаад улсын шүүх, олон улсын болон гадаад улсын байгууллагатай харилцан тохиролцсоноос өөр гадаад улс, олон улсын болон гадаадын байгууллага, гадаадын харьяат иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр гадаад улсад зорчих;

28.1.13.Монгол Улсын олон улсын гэрээгээр гадаад улсын холбогдох шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад Монголын Улсын нутаг дэвсгэрт оршин байгаа гадаад улсын болон олон улсын байгууллага, түүний салбар нэгжийн удирдах бүрэлдэхүүнд орох;

28.1.14.шүүгч багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах;

28.1.15.шүүгч улс төрийн аливаа байгууллагын удирдах болон бусад албан тушаал эрхлэх, улс төрийн байгууллага, сонгуульд нэр дэвшигчийн талаар олон нийтэд хандаж үг хэлэх, сонгуулийнх нь сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, улс төрийн байгууллага, сонгуульд нэр дэвшигчид санхүүжилт олж өгөхийг эрмэлзэх, хандив өгөх;

28.1.16.шүүгч хэргийн оролцогчтой уулзахыг хориглох бөгөөд албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас уулзах бол хэргийн нөгөө талыг оролцуулна;

28.1.17.шүүгч нь хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа шүүхийн нэр хүнд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох аливаа хувийн харилцаа тогтоох;

28.1.18.шүүгч хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах;

28.1.19.шүүгч амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөө гэмт халдлагаас хамгаалах зорилгоор олгосон бие хамгаалах тусгай хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, бусдад ашиглуулах.

28.2.Баяр ёслолын арга хэмжээ, албан томилолтын болон албан ёсны бусад арга хэмжээтэй холбогдуулан бусдаас шүүгчид өгсөн бэлэг сэлтийг төрийн өмчид тооцох бөгөөд хуулиар тогтоосон журмаар өөрөө худалдан авах саналаа гаргаагүй бол шүүгч тэдгээрийг өөрийн ажиллаж байгаа шүүхэд акт, баримттайгаар хүлээлгэн өгнө.

29 дүгээр зүйл.Шүүгчийн иргэний эрхэд тавих хязгаарлалт

29.1.Шүүх эрх мэдлийн бие даасан, шүүгчийн хараат бус, халдашгүй байдлын үндсэн зарчмаас хамааран шүүгчийн хувийн буюу иргэний эрхэд дараах хязгаарлалт тогтооно:

29.1.1.улс төрийн намд харьяалагдах;

29.1.2.улс төрийн нам, олон нийтийн бусад байгууллага болон иргэдэд байр сууриа нийтэд илэрхийлэх;

29.1.3.хөдөлмөрийн маргаанаа зохицуулах зорилгоор албан үүргээ орхих буюу зогсоох.

29.2.Шүүгч улс төрийн аливаа сонгуульд улс төрийн аль нэг намаас буюу бие даан нэр дэвших бол тухайн сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ эрх бүхий этгээдэд гаргана.

29.3.Шүүгч энэ хуулийн 27.2-т заасны дагуу улс төрийн үйл ажиллагаанд оролцож, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа дахин шүүгчээр ажиллахыг хүсвэл хуульд заасан хугацааны дараа шүүгчийн сонгон шалгаруулалтад орно.

30 дугаар зүйл.Шүүгчийн сонирхлын зөрчлийн зохицуулалт

30.1.Шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцоход сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал байгаа бол оролцохоос татгалзах, эсхүл уг болзошгүй нөхцөл байдал үүсч болохыг шүүх ажиллагаанд оролцогчдод мэдэгдэж, тэдгээрийн татгалзан гаргах санал тавих боломжийг хангах үүрэгтэй.

30.2.Шүүгчид шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн, эсхүл тэтгэвэрт гарсны дараа 2 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

31 дүгээр зүйл.Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг

31.1.Шүүгч нь Авлигатай тэмцэх тухай хуульд заасан журмын дагуу хөрөнгө оруулгын мэдүүлгээ үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй.

32 дугаар зүйл.Шүүгчид хүлээлгэх хариуцлага

32.1.Шүүгч зөвхөн хуульд захирагдах, шударга ёсны зарчим болон шүүгчийн ёс зүйг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчиж, шүүх эрх мэдлийн нэр хүндэд харш үйлдэл үйлдсэн бол холбогдох сахилгын болон хуулийн хариуцлага хүлээнэ.

32.2.Шүүгчийн алдаа, гаргасан зөрчлөөс хувь хүн, хуулийн этгээдэд учруулсан гэм хорыг Иргэний хуульд заасан үндэслэлийн дагуу төр хариуцан арилгах бөгөөд харин шүүгч өөрт ногдох хариуцлагыг хуулийн өмнө хүлээнэ.

33 дугаар зүйл. Шүүхийн Ёс зүйн хороо

33.1. Шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий Шүүхийн Ёс зүйн хороо /цаашид “Ёс зүйн хороо” гэх/ нь улсын хэмжээнд нэг байна.

33.2. Ёс зүйн хороо нэр хүндтэй хуульч, эрдэмтэн, судлаач, өндөр насны тэтгэвэрт гарсан шүүгч зэрэг 9 гишүүний бүрэлдхүүнтэй байна.

33.3. Ёс зүйн хорооны гишүүнд бүх шатны шүүхийн зөвлөгөөнөөс нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнд шүүгч, Ерөнхий зөвлөлийн болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор орохыг хориглоно.

33.4. Ёс зүйн хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч батална.

33.5. Ёс зүйн хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.

33.6. Ёс зүйн хорооны гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.

33.7. Ёс зүйн хорооны даргыг хорооны гишүүдийн санал болгосноор Ерөнхийлөгч томилно.

33.8. Ёс зүйн хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хорооны хуралдаан байна.

33.4. Ёс зүйн хороо хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно.

33.6. Ёс зүйн хорооны хуралдааныг гишүүдийн дийлэнх олонх ирсэнээр хүчинтэйд тооцно.

33.7. Ёс зүйн хорооны үйл ажиллагаанд Ерөнхий зөвлөлийн ажлын алба зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.

34 дүгээр зүйл. Ёс зүйн хорооны дарга, гишүүний эрх, үүрэг

34.1. Ёс зүйн хорооны дарга дараах эрх үүрэгтэй:

34.1.1. Ёс зүйн хорооны ажлыг зохион байгуулах, хуралдааныг даргалах;

34.1.2. Өөрийн түр эзгүйд хуралдаан даргалагчийг томилох

34.1.3. Дүрэмд заасан бусад эрх.

34.2. Ёс зүйн хорооны гишүүн дараах эрх, үүрэгтэй:

34.2.1. гомдол, хүсэлтийн дагуу шүүгчид сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах;

34.2.2. гомдол хүсэлтийг шалгаж дүгнэлт гаргах;

34.2.3. сахилгын хэргийг шалгаж шийдвэрлэх бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах;

34.2.4. Ёс зүйн хорооны хуралдаанд таслах эрхтэй оролцох,

35 дугаар зүйл. Шүүгчийн ёс зүйн дүрэм

35.1.Монгол Улсын шүүхийн шүүгч Шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

35.2.Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

36 дугаар зүйл. Сахилгын хэрэг үүсгэх эрх

36.1. Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Ёс зүйн хороонд гомдол гаргана.

36.2. Гомдлыг Ёс зүйн хороо заавал хянан үзнэ.

37 дугаар зүйл. Сахилгын хэрэг үүсгэх

37.1. Ёс зүйн хорооны гишүүн гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шалгана.

37.2. Шалгалтын дүнг Ёс зүйн хороо хянаж, сахилгын хэрэг үүсгэх, эсхүл үүсгэхээс татгалзах тухай тогтоол гаргана.

38 дугаар зүйл. Сахилгын хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн

38.1. Ёс зүйн хороо сахилгын хэргийг 30 хоногийн дотор нийт гишүүдийн ердийн олонхийн ирцтэйгээр хэлэлцэн, хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэж магадлал гаргана.

39 дүгээр зүйл. Ёс зүйн хорооны шийдвэр

39.1. Ёс зүйн хороо сахилгын хэргийг хянан хэлэлцээд дараах шийдвэрийг гаргана:

39.1.1.сахилгын шийтгэл оногдуулах;

39.1.2.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох;

39.1.3.сахилгын хэргийг дахин шалгуулах

39.1.4.шүүгчид эрүүгийн хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох баримтыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх.

39.2. Ёс зүйн хорооны тогтоол, магадлалыг гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор гомдол гаргагчид болон сахилгын хэрэгт холбогдсон шүүгчид хүргүүлнэ.

39.3. Ёс зүйн хорооны тогтоол, магадлалыг хэргийн оролцогчид эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор Ерөнхий зөвлөлд гомдол гаргана.

40 дүгээр зүйл.Шүүгчийн сахилгын хариуцлага

40.1.Шүүгч энэ хууль, шүүгчийн ёс зүйн дүрэм, шүүхийн байгууллага дахь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол түүнд дор дурдсан сахилгын арга хэмжээ авна:

40.1.1.сануулах;
40.1.2.зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг
бууруулах;
40.1.3.огцруулах

40.2. Энэ хуулийн 40.1.3-д заасан сахилгын арга хэмжээг оногдуулахдаа Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

41 дүгээр зүйл.Шүүгчийн хараат бус байдалд халдсан этгээдэд хүлээлгэх хариуцлага

41.1.Энэ хуулийг зөрчиж, шүүгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, хэрэг хянан шийдвэрлэхэд аливаа хэлбэрээр нөлөөлөх, халдахыг оролдсон иргэн, албан тушаалтан, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн эрхтэй болон эрхгүй этгээдэд энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан нөлөөллийн мэдүүлэг болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүсэлтийг үндэслэн эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх журмын дагуу харьяалах шүүх дараах хариуцлага хүлээлгэнэ:

41.1.1.иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;

41.1.2.өмгөөлөгчийн хуульчийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасч, хуульч мэргэжлээр дахин ажиллах хугацааг 10 хүртэл жилээр хязгаарлах;

41.1.3.төрийн байгууллагын албан тушаалтныг эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаалаас нь чөлөөлөх буюу огцруулах;

41.1.4.улс төрийн нам, төрийн бус байгууллага, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээдийн удирдлага, эрх баригч болон тухайн хууль бус нөлөөлөх, халдах үйл ажиллагааг төлөвлөсөн, зохион байгуулсан, үйлдсэн, оролцсон, мэдсэн боловч таслан зогсоох арга хэмжээ аваагүй аливаа ажилтан, этгээдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл уг байгууллагыг албадан татан буулгах буюу татан буулгахгүйгээр гэм буруутай этгээдийг 30 хүртэл хоногоор баривчлах.

41.2.Энэ хуулийн 41.1.3-т заасны дагуу төрийн байгууллагын албан тушаалтныг албан тушаалаас нь чөлөөлөөгүй буюу огцруулаагүй бол шүүхийн журмаар албадан чөлөөлж, огцруулах бөгөөд энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана.

41.3.Энэ хуулийг зөрчиж шүүгчийн хараат бус байдалд нөлөөлсөн, халдсан албан тушаалтныг албан тушаалаас нь энэ хуулийн 41.2-т зааснаар шүүхийн журмаар албадан чөлөөлж, огцруулахад энэ хуулиас бусад хуулиар тогтоосон нөхцөл, журам хэрэглэгдэхгүй бөгөөд саад болохгүй ба энэхүү үндэслэл нь тухайн албан тушаалтныг төрийн албанд дахин ажиллуулахгүй байх үндэслэл болно.

41.4.Энэ хуулийн 41.1-д заасан хариуцлага хүлээсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсаас албадан гаргаж, дахин ирэх эрхийг нь 10 хүртэл жилээр хасна.

41.5.Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хуулийн дагуу нөлөөллийн мэдүүлгийг хүлээн авч, шаардлагатай бусад баримтыг бүрдүүлэн тухайн этгээдийн шүүгчийн хараат бус байдалд халдсан, нөлөөлсөн үйлдлийг эрх бүхий байгууллагад мэдүүлэх, шалгах ажиллагаанд шүүгчийг төлөөлөн итгэмжлэлгүйгээр оролцох, эцэслэн шийдвэрлэх хүртэл байнгын хяналт тавьж, хариуцлага хүлээлгэх хүртэл хариуцан ажиллана.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

42 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

42.1.Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ